

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/8/-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Аудитын менежер: Аудитын менежер

Утас: 70342716

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл	11
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	

Аудитын гэрчилгээ

 БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР	СЭЛЭНГЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА Ш.НАСАНДУЛАМ ТАНАА
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580	
<i>2020.03.28</i> № <i>134</i>	
Танай _____	-ны № _____
Т _____	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заасны дагуу Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Хязгаарлалттай санал дүгнэлт	
<p>Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p> <p>Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p> <p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Аудитаар илэрсэн алдаа зөрчил нь урьдчилан тооцоолсон материаллаг түвшингээс их, сумын Засаг даргын тамгын газар "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан. Аудитаар дээрх байгууллага нь санхүүгийн программ ашигладаггүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, зардлыг эдийн засгийн ангиллын</p>	
006020195	

дагуу зарцуулаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан үүргийг нягтлан бодогч хэрэгжүүлээгүй, тооллогын комисст бэлтгэл ажлыг хангаж өгөөгүй, бараа материалын анхан шатны баримт байгаа боловч тайлан хийгээгүй, тооцоо бодсон акт байхгүй, бараа материалын дансны ангиллыг стандартын дагуу бүртгээгүй нийт 159538.8 мянган төгрөг алдаа зөрчил илэрсэн,


Сумын Засаг дарга Бсловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн,

ИТХ-аар баталсан зам засварын 24000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний зардлаас сэлбэг хэрэгслийн зардалд 7600.0 мянган төгрөгийг зориулалт бус зардал гаргасан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал, гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



Аудитын тайлан

2.1. Оршил

Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Ш.Насандулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дүгээр сарын 05-аас 2020 оны 03 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн 01/119 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, таниулах замаар төрийн үйлчилгээг жигд шуурхай хүргэх, төр нийгмийн ажилд иргэдийг өргөнөөр оролцуулах, тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа-1)
- (Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа-2)
- (Ерөнхий боловсролын сургалтын үйл ажиллагаа-3)
- (Соёл болон бусад нийгмийн үйлчилгээг зохицуулдаг төрийн байгууллагын үйл ажиллагаа-4)
- (Сумын эмнэлгийн тусламж үйлчилгээ-5)

Сумын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомжууд Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/
- Төсөв баталсан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Төсөв баталсан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох)
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох)
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох)
- Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12 -ны өдрийн 228 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам)
- Сангийн сайдын 2007 оны 11 дугаар сарын 30 -ны өдрийн 326 дугаар тушаал (Журам батлах тухай Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сэлэнгэ сумын төсвийн байгууллагууд нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Си Ти Эс программ хангамж ашигладаг, санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны Э-тайланг ашиглаж байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3572857.0 мянган төгрөгөөс тооцон 71457.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3572857.0 мянган төгрөгөөр 71457.1 тооцлоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сэлэнгэ сумын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65648047.6 мянган төгрөгөөр буюу 0.01 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	95818388.84	90941165.7	4,877,223.14

Авлага	197,947,06.3	260657996.08	62,710,929.78
Урьдчилгаа			
Бараа материал	405,805,136.52	409,683,841.52	3,878,705
Үндсэн хөрөнгө	3,255,045,723.54	3,127,685,264.28	-127,360,459.26
Нийт хөрөнгө	3,954,616,315.2	3,888,968,267.58	65,648,047.62
Өр төлбөр	18,265,414.01	25,384,727.57	7,119,313.56
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,586,832,611.83	1,586,832,611.83	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,954,616,315.2	3,888,968,267.58	65,648,047.62

Авлага дансны үлдэгдэл өссөн нь цэцэрлэг ХАОАТ илүү тушаасан 2.8 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн зээлийн алданги тухай оны хүүгийн авлага 25.9 сая төгрөг, сум хөгжүүлэх санд зээл гаргасан 76.9 сая төгрөгийн авлагаар нэмэгдсэн.

Авлага дансны үлдэгдэлд 2011-2018 онуудад үүссэн, он удаан жил болсон 9345.3 мянган төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах 183503.5 авлага байна.

Үүнээс сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалж улмаар барагдах боломжгүй болох эрсдэлтэй 93599.3 мянган төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлээд байна. Энэ нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэлтгүй болох, эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3878.7 мянган төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагууд хөрөнгө бэлдсэнтэй холбоотой нэмэгдсэн, оны эцэст 49478.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нь хичээлийн хэрэгсэл, нөөтбүк, тоног төхөөрөмжийн худалдан авалт хийж бараа материалын дансанд бүртгэсэнтэй холбоотой өссөн байна. Хөрөнгийн ангиллыг буруу бүртгэснийг залруулах талаар төсвийн шууд захирагчид зөвлөмж хүргүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 111692.8 мянган төгрөгөөр өссөн нь цэцэрлэг компьютер, хүүхдийн ширээ сандал, ор шкаф, зурагт сургууль гал тогооны ширээ сандал, кабинетын зурагт, ном хашаа, ЗДТГазар цэцэрлэгт хүрээлэн, хандиваар ирсэн компьютер принтер, соёлын төв ном, эрүүл мэндийн төв шилжүүлж ирсэн мобайл технологи зэргээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 78577.8 төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 20534.0 төгрөг, шилжүүлж авсан 12581.0 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, акталсан 6196.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 25384.6 мянган төгрөг өмнөх оноос 7119.2 өссөн нь бүрэн дунд сургууль, соёлын төв НДШ-д 2080.3 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сан эмийн 18145.3, Ингэт дөл ОНӨААТҮГазар 5159.1 мянган төгрөгийн цалингийн өр төлбөрөөс шалтгаалж нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2017-2019 онуудын 25384.7 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө нийт өр төлбөрийн 0.6 хувийг эзэлж байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд 144261.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 198594.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 137.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	5,000,000	8,644,689.07	3,644,689.07	172.8
Хөрөнгийн орлого	13,000,000	13,707,042.29	707,042.26	105.4
Шууд бус орлого	31,740,000	38,051,666.23	6,311,666.2	119.8
Бууны албан татвар	2,384,000	2,608,494	224,494	109.4
Улсын тэмдэгтийн хураамж	4,779,000	2,487,440	-2,291,560	52.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,091,600	3,879,892.91	-1,211,707	76.2
Ашигт малтмалаас бусад байгалийн нөөц ашигласны зөвшөөрөл олгох	6,000,000	1,236,000	-4,764,000	20.6
Ойн нөөц ашигласны төлбөр	59,239,000	52,832,021	-6,406,979	89.2
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,528,000	1,346,000	-182,000	88.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	9,000,000	29,572,720	20,572,720	328.5
Торгуулийн орлого	6,500,000	44,228,453	37,728,453	680.4

2019 оны төсвийн орлого 51378.8 мянган төгрөгөөр давсан нь газар тариалангийн компани газрын дуудлага худалдааны анхны үнээс 10% тооцож Булган аймаг дахь Төрийн аудитын газрын акт төлбөр барагдуулах тухай ирсэн албан шаардлагын дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлж, үйл ажиллагааны орлого 3644.6, арилжааны банкнуудын мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого төлөвлөгөөнөөс илүү дансанд төвлөрч хөрөнгийн орлого 0.7 төгрөгөөр, төсөвт байгууллагуудын худалдан авалттай холбоотой хувь хүнээс суутгасан татвар төлөвлөснөөс илүү төсөвт төвлөрч шууд бус орлого 6311.6, галт зэвсгийн албан татвар төлөгч иргэн нэмэгдэж бүртгэл, гэрчилгээжүүлсний үндсэн дээр орон нутагт татвар төвлөрүүлж бууны албан татварын орлого 224.4, ус, рашаан ашигласны төлбөр газар тариалан эрхлэгч аж ахуй нэгж байгууллагууд болон Шар Нарст ХХК-аас усны орлого орон нутгийн дансанд төвлөрч ус рашааны төлбөрийн орлого 20572.7, цагдаагийн торгуулийн орлого болон татварын хүү, торгуулийн орлого мөн Шар Нарст ХХК-ны торгуулийн орлого дансанд төвлөрч торгуулийн орлого 37728.4 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол сумын худалдааны үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн тусгай зөвшөөрлийн хугацаа сунгалт хийгдэхгүйгээс улсын тэмдэгтийн хураамж 2291.5, Сэлэнгэ суманд 2019 онд Хуш модны хуваарь хийгдээгүй тул ойн нөөцийн орлого 6406.9, хог хаягдлын

үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөр дээр нэмж авах ЭБДЦСтанцтай хамтран ажиллах гэрээ удаашралттай байсантай холбоотой хог хаягдлын хураамжийн орлого 1211.7, байгаль хамгаалагчдаас ан, амьтан барих эрхийн зөвшөөрлийн хураамж анчид бага авсантай холбоотой ан амьтны хураамжийн орлого 182.0, 2019 оны байгалийн ургамал ашигласны орлого ЗХБНДЦГазар, Тэшиг сумтай хамтарч ажиллаж орлого Тэшиг суманд төвлөрснөөс ашигт малтмалаас бусад байгалийн нөөц ашигласны орлого 4764.0 төгрөгөөр тус тус тасалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт зориулан 2808889.7, урсгал зардалд 2678889.7, хөрөнгийн зардалд 130000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2579287.7 мянган төгрөгийг улсын орон нутгийн төсвөөс, 34999.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 95784.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 98818.1 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Засгийн газрын нөөц сан Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 233633.9, дээд шатны төсвийн захирагчаас 17098.7, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2073.0 нийт 258309.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин урамшуулалд 2432.0, түлш халаалтын зардалд 2073.0, тээвэр шатахууны зардалд 2088.1 төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 10000.0, албан томилолтын зардалд 528.5 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 25098.5, бараа үйлчилгээний бусад зардалд 200700.0, хичээл практикийн зардалд 9855.6 мянган төгрөгийг тус тус зарцуулаад байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 170139.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 900.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 160100.0 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 9139.7 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар аудитаар илэрсэн 14941.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумын Засаг дарга Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн

урамшуулал олгох шийдвэр гаргасан нь тус хуулийн 30 дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн, мөн ИТХ-аар баталсан зам засварын 24000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний зардлаас сэлбэг хэрэгслийн зардал 7600.0 мянган төгрөгийг зориулалт бус зардал гаргасан байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 109 мэдээллийг хугацаанд нь, 42 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр ав хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэсэн 3 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Сэлэнгэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг харьцуулсан дүнгээрээ 51378.8 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үйл ажиллагааны орлого 3644.7, шууд бус орлого 6490.6, ус рашаан ашигласны төлбөр 20572.7, хүү, торгуулийн орлого 34715.4 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол байгалийн ургамал ашигласны төлбөр 4764.0, ойн нөөц ашигласны төлбөр 6406.9, улсын тэмдэгтийн хураамж 2291.5, хог хаягдлын хураамж 1211.7 нийт 14941.2 мянган төгрөгийн орлогыг тус тус тасалсан байна.

3.1.2 Эрсдэл:

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, төсвийн орлого тасарснаас эх үүсвэр дутагдах, хууль журам зөрчигдөх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэнд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.2. Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 170139.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 900.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 160100.0 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 9139.7 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

3.3 Удирдлагатай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Сумын Засаг дарга Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь тус хуулийн 30 дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн, мөн ИТХ-аар баталсан зам засварын 24000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний зардлаас сэлбэг хэрэгслийн зардал 7600.0 мянган төгрөгийг зориулалт бус зардал гаргасан,

Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх.

3.3.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсөв захирагч нар хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд төсвийг захиран зарцуулах эрх зүйн актыг гаргаж байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

Төсвийн захирагч зөвшөөрсөн Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>699,570,591.66</u>	<u>761,283,003.30</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	95,818,388.84	90,941,165.70
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	95,818,388.84	90,941,165.70
3121	Төгрөг	95,818,388.84	90,941,165.70
31211	Төрийн сангийн харилцах	95,785,423.20	90,839,169.70
31213	Арилжааны банк дахь харилцах	32,965.64	101,996.00
33	АВЛАГА	197,947,066.30	260,657,996.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		2,881,897.10
33400	Зээлийн хүүгийн авлага	4,087,636.00	25,991,899.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	10,560.30	436,329.98
335	Бусад авлага	193,848,870.00	231,347,870.00
3351	Байгууллагаас авах авлага	9,345,354.00	13,832,354.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	184,503,516.00	217,515,516.00
35	БАРАА МАТЕРИАЛ	405,805,136.52	409,683,841.52
351	Түүхий эд материал	13,725,345.80	21,498,601.36
35130	Эм боох материал	13,725,345.80	21,498,601.36
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,141,573.40	6,526,538.62
354	Хангамжийн материал	358,361,817.32	366,877,101.54
35420	Аж ахуйн материал	45,272,239.00	48,610,109.00
35440	Түлш, шатах тослох материал	-	2,439,900.00
35460	Хүнсний материал	14,540,965.50	24,898,938.60
35470	Бусад хангамжийн материал	298,548,612.82	290,928,153.94
35600	Мал амьтад	26,576,400.00	14,781,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,255,045,723.54</u>	<u>3,127,685,264.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,255,045,723.54	3,127,685,264.28
392	Биет хөрөнгө	3,146,927,723.54	3,019,567,264.28

